



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020.08.24 № 09

Асуулга тавих тухай

Дэлхийн дулаарал, хүн амын өсөлт, байгаль, цаг уурын өөрчлөлт, техник технологийн хөгжил зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан дэлхийн цэвэр усны нөөц минут, секундээр хомсдож, зарим улс орон цэвэр усны нөөцгүй болж байгааг холбогдох олон улсын байгууллага, судлаачид анхааруулсаар байна.

Манай улсын хувьд ч сүүлийн жилүүдэд цэвэр усны зохисгүй хэрэглээ, байгаль, цаг уурын өөрчлөлт болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан усны нөөц эрс багасч байгаа талаар мэргэжлийн байгууллагууд мэдээлэх болсон. Тэр дундаа говийн бүс нутагт газрын гадаргын болон гүний цэвэр усыг зохисгүй ашиглах, уул уурхайн олборлолт дагасан томоохон дэд бүтэц, хот суурин газрууд усыг үнэ төлбөргүйгээр ашиглах, үйлдвэрлэл, үйлчилгээнд маш хямд өртөгөөр их хэмжээний гүний ус ашиглаж байгаа нь экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах, цөлжилтийг ихээр нэмэгдүүлэх, цэвэр усны хомсдолд орох, гол горхи, булаг шанд ширгэх, говийн бүсэд цөлжилт, хуурайшилт эрчимтэй явагдах гол үндэс суурь нь болоод байна.

Цаашид усыг зохистой ашиглах, дахин ашиглах, гадагш урсгалтай томоохон гол мөрөнд урсацын тохируулга хийх, хиймэл усан сангийн хуримтлал үүсгэх, томоохон хот суурин газруудын саарал усыг хөдөө аж ахуйн болон уул уурхайн олборлолт, үйлчилгээнд ашигладаг болох чухал шаардлага үүссэн байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасанг үндэслэн Монгол улсын Ерөнхий сайд Танд асуулга тавьж байна.

1. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд усны харилцааг зохицуулах Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Ус” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”, УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”, 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсаар байх боловч эдгээрт тусгагдсан усыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зорилго,


2020080945

зорилтууд хангалтгүй хэрэгжсээр өнөөдрийг хүрлээ гэж иргэд дүгнэж байна. Дээрх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд та бүхэн хэрхэн хяналт тавьж байгаа, ямар хугацаагаар үнэлэлт, дүгнэлт өгдөг, үр дүнг хэрхэн хэлэлцэж, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч байгаа болон дээрх баримт бичгүүдээс хэрэгжих хугацаа нь дууссан баримт бичгүүдийн үр дүнгийн талаар;

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6 дугаар бүлгийн 6.3.2-д “Усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамаарсан шатлан өгсөх зарчимд суурилан тогтоох, төлбөрийн орлогыг дахин хуваарилах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж 1 дүгээр үе шатанд хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Гэтэл энэхүү зорилт хэрэгжихэд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиуд нийцэхгүй байна. Холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар;
3. Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд усны төлбөр Монгол Улсын 29 ай сав газар тус бүрт 1 шоо метр усны үнийг тооцох аргачлал нь Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ”, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ”, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “ашиглалтын зориулалт тооцох итгэлцүүр”-ээр өөр өөр байгаа нь өнөөгийн нийгэм эдийн засгийн байдал, усны нөөц, эх үүсвэртэй нь уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна. Ус ашигласны төлбөрийн хэмжээг тогтоохдоо ямар үндэслэлээр тогтоосон, ямар судалгаа, шинжилгээний ажил хийсэн талаар;
4. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ”-г баталсан Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын үндэслэл болох Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт нь 2004-2012 оны үед мөрдөгдөж байсан хүчингүй болсон Усны тухай хуулийн заалттай байна. Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолыг Усны тухай хуулийн /2012 онд шинэчлэн найруулсан/ 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын дагуу шинэчлэхэд хэрэгжүүлж байгаа ажлын талаар;
5. Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар усны нөөц ашигласны төлбөрөөс хөнгөлөх хувь хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн төлбөрөөс хөнгөлөх заалтыг барьж 100 хувь усны төлбөрөөс хөнгөлөх тогтоол гаргасан нь усны төлбөрөөс чөлөөлөх боломжгүй этгээдийг чөлөөлөх хуулийн цоорхой болсон. Иймд тогтоолд өөрчлөлт оруулж, зөвхөн тодорхой хувийг нь хөнгөлж, үлдсэн хувь дээрх төлбөрийг төсөвт төвлөрүүлдэг болгох.

Асуулгын заалт тус бүрт хариу тайлбарыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, улмаар хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.БАТ-ЭРДЭНЭ

2020000045